



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Засгийн газрын агентлагийн бүтэц,
орон тооны талаар хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18⁴ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулан ажиллуулсугай.

2.Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч зарим агентлагийн орон тооны дээд хязгаарыг 2 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.

3.Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загварыг 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

4.Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн зохион байгуулалтын бүтцийг батлахдаа дараах чиглэлийг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай:

4.1.хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь дэд дарга, орлогч даргагүй байх;

4.2.Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, компани, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх;

4.3.ерөнхий газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар нэгжтэй агентлагийн бүтцийн нэгжийг газар, газар нь дотроо хэлтэстэй, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар нэгжгүй агентлагийн

бүтцийн нэгжийг хэлтэс, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар тус тус өөрчлөн зохион байгуулах;

4.4.ерөнхий газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар нэгжтэй агентлагийн зохион байгуулалтын бүтцийг орон тооны хязгаар 50 хүртэл бол 4, 80 хүртэл бол 5, 110 хүртэл бол 6, 140 хүртэл бол 7, 170 хүртэл бол 8, 170-аас дээш бол 9 газартай байх, үндсэн чиг үүргийн газар дотор 1-ээс илүү хэлтэс байгуулахгүй байх, нийтлэг чиг үүргийн газар дотор хэлтэс байгуулахгүй байх;


4.5.аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар нэгжгүй агентлагийн зохион байгуулалтын бүтцийг орон тооны хязгаар 50 хүртэл бол 4, 80 хүртэл бол 5, 110 хүртэл бол 6, 140 хүртэл бол 7, 170 хүртэл бол 8, 170-аас дээш бол 9 хэлтэстэй байх;

4.6.Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын шууд харьяалалд хамаарах Засгийн газрын агентлагаас бусад агентлагийн зохион байгуулалтын бүтцийг бодлогын асуудал хариуцсан нэгжгүй байхаар, бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байхаар тус тус зохион байгуулах;

4.7.үндсэн чиг үүрэг хариуцсан нэгжийн орон тоог нийтлэг чиг үүрэг хариуцсан нэгжийн орон тооноос илүү байхаар тогтоох.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод үүрэг болгосугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ



Засгийн газрын 2025 оны 08 дугаар
сарын 20-ны өдрийн 52 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГИЙН ЖАГСААЛТ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Тагнуулын ерөнхий газар -Төрийн тусгай хамгаалалтын газар	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар -Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Оюуны өмчийн газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Хөрөнгө оруулалт, худалдааны газар -Төрийн худалдан авах ажиллагааны газар -Монополын эсрэг газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Онцгой байдлын ерөнхий газар -Стандарт, хэмжил зүйн газар	
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Гаалийн ерөнхий газар -Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Цагдаагийн ерөнхий газар -Хил хамгаалах ерөнхий газар	-Улсын бүртгэлийн ерөнхий газар -Архивын ерөнхий газар -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар -Гадаадын иргэн, харьяатын газар -Шүүх шинжилгээний ерөнхий газар
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Ашигт малтмал, газрын тосны газар -Үндэсний геологийн алба

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Зэвсэгт хүчний жанжин штаб	
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Цаг уур, орчны шинжилгээний газар -Усны газар -Ойн газар
Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Боловсролын ерөнхий газар
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Нийгмийн даатгалын ерөнхий газар -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар -Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Иргэний нисэхийн ерөнхий газар	-Төмөр замын газар
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Соёл, урлагийн газар -Биеийн тамир, спортын улсын хороо
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Мал эмнэлгийн ерөнхий газар -Жижиг, дунд үйлдвэрийн газар -Ургамал хамгааллын газар
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар



Засгийн газрын 2025 оны 08 дугаар
сарын 20-ны өдрийн 52 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ЗАРИМ АГЕНТЛАГИЙН ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Агентлагийн нэр	Орон тооны хязгаар
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	51
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	85
3	Оюуны өмчийн газар	54
4	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	27
5	Төрийн худалдан авах ажиллагааны газар	49
6	Монополын эсрэг газар	33
7	Стандарт, хэмжил зүйн газар	181
8	Гаалийн ерөнхий газар	127
9	Татварын ерөнхий газар	100
10	Цагдаагийн ерөнхий газар	298
11	Улсын бүртгэлийн ерөнхий газар	146
12	Архивын ерөнхий газар	82
13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	101
14	Гадаадын иргэн, харьяатын газар	130
15	Шүүх шинжилгээний ерөнхий газар	118
16	Ашигт малтмал, газрын тосны газар	180
17	Үндэсний геологийн алба	32
18	Цаг уур, орчны шинжилгээний газар	70
19	Усны газар	35
20	Ойн газар	35

21	Боловсролын ерөнхий газар	91
22	Нийгмийн даатгалын ерөнхий газар	84
23	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	83
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	32
25	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	56
26	Иргэний нисэхийн ерөнхий газар	96
27	Төмөр замын газар	35
28	Соёл, урлагийн газар	41
29	Биеийн тамир, спортын улсын хороо	63
30	Мал эмнэлгийн ерөнхий газар	39
31	Жижиг, дунд үйлдвэрийн газар	46
32	Ургамал хамгааллын газар	19
33	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	158
34	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	155
35	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	120

----o0o----



Засгийн газрын 2025 оны 08 дугаар
сарын 20-ны өдрийн 52 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ЗАГВАР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн зорилго, агуулгыг бичнэ);

1.2.Үндэслэл (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэлийг бичнэ);

1.3.Хууль, эрх зүйн орчин (энэ хэсэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль тогтоомжийг тодорхой бичнэ);

1.4.Арга зүй (энэ хэсэгт хөтөлбөрийг боловсруулахад ашигласан нийтлэг болон салбарын онцлогт нийцсэн арга зүйг бичнэ);

1.5.Агентлагийн үүрэг, хариуцлагын хуваарь (энэ хэсэгт эрхлэх асуудлын хүрээний дагуу сайдын өмнө хүлээх үүрэг, хариуцлага, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой бичнэ);

1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч (энэ хэсэгт агентлагийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг тодорхойлж, тэдэнд үзүүлэх үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэглэгч тус бүрээр тодорхойлж бичнэ).

Хоёр.Агентлагийн үйл ажиллагааны стратеги

2.1.Үйл ажиллагааны стратегийн мөн чанар (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны мөн чанарыг хураангуй байдлаар тодорхойлж бичнэ);

2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг бүлэглэн тодорхойлж, ач холбогдлын эрэмбийн дарааллаар бичнэ);

2.3.Эрхэм зорилго (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг товч, тодорхой байдлаар бичнэ);

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт (энэ хэсэгт зөвхөн агентлагийн үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх стратегийн зорилтыг тодорхойлох бөгөөд стратегийн зорилтоос агентлагийн зохион байгуулалтын ерөнхий бүтэц, бүтцийн нэгжүүд тодорхойлогдох арга зүйг баримтлан бичнэ);

2.5.Үйл ажиллагааны гол зорилт (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны гол зорилтуудыг тодорхойлж бичнэ);

2.6.Үйл ажиллагааны зорилт (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн чиг үүргийг тодорхойлох, нэгжийн албан хаагч тус бүрийн албан тушаалын тодорхойлолтод тусгахаар тодорхойлж бичнэ);

2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар (энэ хэсэгт агентлагийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилтыг зураглаж харуулна).

Гурав.Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо,
зохион байгуулалтын бүтцийн нэгжийн
үндсэн чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим (энэ хэсэгт агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад баримтлах зарчим (стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх, эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх, үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх, бүтцийн хувьд энгийн, ойлгомжтой, чиг үүргийн давхардалгүй байх, тэнцвэрт байдлыг хангах, хяналтын хүрээг тогтоосон байх, бүрэн чадавхтай, бодитой үйл ажиллагаатай байх, улс төрөөс ангид байх)-уудыг тодорхойлж бичнэ);

3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар (энэ хэсэгт стратегийн зорилтод тулгуурласан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг оноосон нэр хэрэглэхгүйгээр зураглаж харуулна);

3.3.Зохион байгуулалтын бүтэц (энэ хэсэгт үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн чиг үүргийг тодорхойлно. Тухайн нэгжийн үндсэн чиг үүрэг нь стратегийн зорилтын хүрээний үйл ажиллагааны гол зорилтууд байна. Зохион байгуулалтын бүтцийн нэгж бүрийн үндсэн чиг үүргийг тодорхойлсны үндсэн дээр тухайн нэгжийн хүлээх хариуцлага, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч, тэдэнд үзүүлэх үйлчилгээний төрлийг хэрэглэгч бүрээр тодорхойлж бичнэ).